



МАСКАА ЗҮҮЕ



ГАРАА УГААЯ



ЗАЙГАА БАРЬЯ



# УСНЫ САЛБАРЫН ЭРГЭН ТОЙРОНД



MILLENNIUM CHALLENGE CORPORATION UNITED STATES OF AMERICA

Долоо хоног тутмын мэдээ мэдээлэл - Монголын Мянганы сорилтын сан

№2 (06)

2021.02.08


## БХБЯ БОЛОН УЛААНБААТАР ХОТЫН ЗАХИРАГЧИЙН АЖЛЫН АЛБАНЫ ДЭРГЭДЭХ АЖЛЫН ХЭСГҮҮД “ҮЙЛДВЭРИЙН ХАЯГДАЛ УСЫГ УРЬДЧИЛСАН ЦЭВЭРЛЭХ ТӨЛӨВЛӨГӨӨ”-НИЙ ТӨСЛИЙГ АВЧ ХЭЛЭЛЦЛЭЭ



Монгол Улсын Засгийн газрын Компакт гэрээгээр хүлээсэн үүрэг, амлалтын хэрэгжилтийг хангах зорилгоор Барилга, хот байгуулалт (БХБ)-ын сайдын тушаалаар байгуулагдсан Ажлын хэсэг болон Нийслэлийн Засаг даргын захирамжаар байгуулагдсан Ажлын хэсэг хамтран хуралдаж, “Үйлдвэрийн хаягдал усыг урьдчилан цэвэрлэх төлөвлөгөө”-ний төслийг авч хэлэлцлээ. Төв цэвэрлэх байгууламж руу үйлдвэр, аж ахуйн газруудаас нийлүүлж буй хаягдал усан дахь химийн бодисын агууламжийг 2013 оны түвшин, эсхүл түүнээс бага хэмжээнд хүргэх зорилгоор холбогдох яам, агентлаг, бохирдол ялгаруулж буй үйлдвэр, аж ахуйн нэгжийн төлөөлөлтэй хамтран Монголын МСС-аас боловсруулаад буй “Үйлдвэрлэлийн хаягдал усыг урьдчилан цэвэрлэх төлөвлөгөө”-ний төслийн талаар Монголын МСС-ийн Гүйцэтгэх захирал Э.Содонтогос, Хаягдал ус дахин боловсруулах төслийн захирал Т.Хишигт нар дэлгэрэнгүй танилцуулж, хуралд оролцогчдын тодруулга асуултуудад хариулт тайлбар өгөв. Улмаар холбогдох талууд болох БХБЯ, ХХААХҮЯ, БОАЖЯ, Улаанбаатар хот, түүнчлэн үйлдвэр, аж ахуйн нэгжүүдийн удирдлагууд хамтран шаардлагатай зарим хэсгүүд дээр хамтран ажиллаад, энэ сардаа багтаан дахин хэлэлцэж Засгийн газрын хуралд оруулахаар тохиролцлоо.

[Эх сурвалж: Монголын МСС, МОНЦАМЭ агентлаг](#)

## УС БОХИРДУУЛСНЫ ТӨЛБӨРИЙГ E-MONGOLIA АППЛИКЭЙШН АШИГЛАН ЦАХИМААР ТӨЛӨХ БОЛОМЖТОЙ



Хаягдал усан дахь бохирдлыг үе шаттай бууруулж, улмаар байгаль орчинд учруулж буй сөрөг нөлөөллийг багасгах, нийт усны нөөцийг хамгаалах, усыг зүй зохистой дахин ашиглах зорилгоор Ус бохирдуулсны төлбөрийн тухай хуулийг 2012 оны 5 дугаар сарын 17 онд баталсан бөгөөд 2015, 2017, 2019 онд тус тус нэмэлт, өөрчлөлтүүд орж, шаардлагатай эрх зүйн бичиг баримтуудыг баталснаар хэрэгжиж эхлээд байгаа. Тэгвэл өнгөрсөн оны сүүлчээс эхлэн компани аж ахуйн нэгжүүд Ус бохирдуулсны төлбөрөө e-mongolia аппликэйшныг ашиглан цахимаар төлөх боломжтой болжээ. Төлбөрийн орлогыг усны нөөцийг хамгаалах, усны бохирдлыг бууруулах хяналт-шинжилгээ хийх, нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах ба ингэхдээ 50-иас доошгүй хувийг цэвэрлэх байгууламжийн шинэчлэл, засвар үйлчилгээнд зарцуулахаар хуульд заасан.

[Эх сурвалж: e-mongolia](#)


## ХАР НУУР-ХОВД ГОЛЫН САВ ГАЗРЫН УРТ ХУГАЦААНЫ УСНЫ НӨӨЦИЙН НЭГДСЭН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ БОЛОВСРУУЛНА



Хар нуур-Ховд голын сав газрын захиргаа нь Дэлхийн байгаль хамгаалах сан (WWF)-гийн Монгол дахь хөтөлбөрийн газрын дэмжлэгтэйгээр Хар нуур-Ховд голын сав газрын урт хугацааны усны нөөцийн нэгдсэн менежментийн төлөвлөгөөг боловсруулахаар ажиллаж байгаа бөгөөд төлөвлөгөөний боловсруулалтад дүн шинжилгээ хийх, мэргэжил аргагүйн зөвлөгөө өгөх, удирдамжаар хангах, сав газрын захиргаа болон бусад талтай хамтран ажиллах богино хугацааны зөвлөхийн сонгон шалгаруулалтыг зарласан байна. Төлөвлөгөө боловсруулах ажилтай холбоотойгоор тус сав газрын захиргаанаас 2021 оны 1 дүгээр сарын 25-ны өдөр мэргэжлийн байгууллага, эрдэмтэн судлаач, төсөл хөтөлбөрүүд, ус хэрэглэгч, ашиглагч, бохирдуулагч нарын төлөөллийг оролцуулсан "Усны нөөцийн нэгдсэн менежментийн төлөвлөгөөнд санал авах" уулзалт, хэлэлцүүлгийг нийт 24 хүний бүрэлдэхүүнтэй, хоёр үе шаттайгаар амжилттай зохион байгуулжээ.

[Эх сурвалж: Дэлхийн байгаль хамгаалах сан Монгол Фэйсбүүк хуудас](#)

## ЦЭНГЭГ УСНЫ НӨӨЦ, БАЙГАЛЬ ХАМГААЛАХ ТӨВӨӨС МОНГОЛ ОРНЫ УС, НАМГАРХАГ ГАЗРУУДЫН ТАЛААР СУРАГЧДАД ЦАХИМААР МЭДЭЭЛЭЛ ХҮРГЭЛЭЭ



Олон улсын ач холбогдол бүхий ус, намгархаг газар, ялангуяа усны шувууд олноор амьдардаг орчныг хамгаалах тухай /Рамсар/ конвенцыг баталсан хоёрдугаар сарын 2-ны өдрийг дэлхийн “Ус, намгархаг газрын өдөр” болгон жил бүр тэмдэглэн өнгөрүүлдэг. Энэ жил тус өдрийг "Ус, намгархаг газар, амьдрал гурав салшгүй холбоотой" уриан дор дэлхий нийтээрээ тэмдэглэн өнгөрүүлсэн бөгөөд Цэнгэг усны нөөц, байгаль хамгаалах төвөөс Монгол орны ач холбогдол бүхий Ус намгархаг газрууд болох 11 нуурын талаар мэдээллийг Ерөнхий боловсролын 32 дугаар сургуулийн “Эко клуб”-ийн 25 сурагчдад цахимаар хүргэжээ.

[Эх сурвалж: Цэнгэг усны нөөц, байгаль хамгаалах төв](#)